

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317

Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799

Цахим хаяг: Bat-Amgаланm@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батсайхан

Утас: 70453799

Цахим хаяг: batsaikhanS@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

МАЛЧИН СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.АРИУНБОЛД ТАНАА

2023.02.24 № УВА-2023/63/НА-СТА-ТШЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 1.5 сая төгрөгийн аж ахуйн материал, 2.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил акталсан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200131

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,540,000.00</u>	<u>1,040,000.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,540,000.00	1,040,000.00
354	Хангамжийн материал	2,540,000.00	1,040,000.00
35420	Аж ахуйн материал	2,540,000.00	1,040,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,617,510.35</u>	<u>6,184,572.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,617,510.35	6,184,572.91
392	Биет хөрөнгө	9,617,510.35	6,184,572.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	9,013,889.00	9,013,889.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,384,838.07	-9,013,889.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,553,800.00	4,611,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,326,349.99	-3,158,429.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,173,400.00	10,822,400.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,412,390.59	-7,369,630.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	00.00	1,300,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-21,666.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>12,157,510.35</u>	<u>7,224,572.91</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>12,157,510.35</u>	<u>7,224,572.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	12,157,510.35	7,224,572.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,888,400.00	1,888,400.00
51101	Өмч: - төрийн	1,888,400.00	1,888,400.00
512	Хуримтлагдсан үр дүн	10,269,110.35	5,336,172.91
51210	Өмнөх үеийн үр дүн	10,269,110.35	10,269,110.35
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-4,932,937.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>12,157,510.35</u>	<u>7,224,572.91</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	77,666,600.00	93,478,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	77,666,600.00	93,478,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,166,600.00	93,478,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,166,600.00	93,478,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	80,994,872.72	98,411,837.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,994,872.72	98,411,837.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,910,581.72	96,474,976.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,305,775.00	48,826,894.25
210101	Үндсэн цалин	35,264,295.00	35,660,651.85
210102	Нэмэгдэл	00.00	4,589,782.40
210104	Урамшуулал	10,041,480.00	8,576,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,836,450.00	6,067,971.30
210201	Тэтгэврийн даатгал	4,065,640.60	4,126,082.66
210202	Тэтгэмжийн даатгал	453,057.75	485,596.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,446.24	388,277.16
210204	Ажилгүйдлийн даатгал	86,845.91	97,318.57
210205	Эрүүл мэндийн даатгал	868,459.50	970,696.19
2104	Хангамж, бараа материалын зардал	3,632,510.00	6,825,400.00
210401	Бичиг хэрэг	999,900.00	1,230,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,610.00	5,169,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,959,400.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	4,959,400.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	495,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	495,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,601,374.00	13,215,974.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,193,400.00	12,904,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,974.00	51,974.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	212,000.00	170,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,080,072.72	11,338,737.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,728,800.00	3,781,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	833,000.00	2,824,200.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,518,272.72	4,732,937.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,084,291.00	1,936,860.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,463,200.00	635,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	635,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,621,091.00	1,301,860.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,621,091.00	1,301,860.45
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,328,272.72	-4,932,937.44
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,328,272.72	-4,932,937.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	77,666,600.00	93,478,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	77,666,600.00	93,478,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	500,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	77,166,600.00	93,478,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	77,166,600.00	93,478,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	77,666,600.00	93,478,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	77,666,600.00	93,478,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	69,582,309.00	91,542,039.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,305,775.00	48,826,894.25
210101	Үндсэн цалин	35,264,295.00	35,660,651.85
210102	Нэмэгдэл	00.00	4,589,782.40
210104	Урамшуулал	10,041,480.00	8,576,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,836,450.00	6,067,971.30
210201	Тэтгэврийн даатгал	4,065,640.60	4,126,082.66
210202	Тэтгэмжийн даатгал	453,057.75	485,596.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	362,446.24	388,277.16
210204	Ажилгүйдлийн даатгал	86,845.91	97,318.57
210205	Эрүүл мэндийн даатгал	868,459.50	970,696.19
2104	Хангамж, бараа материалын зардал	3,632,510.00	6,825,400.00
210401	Бичиг хэрэг	999,900.00	1,230,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,610.00	5,169,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	250,000.00	425,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,999,400.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	5,999,400.00	10,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	495,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	495,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,601,374.00	13,215,974.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,193,400.00	12,904,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	51,974.00	51,974.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	212,000.00	170,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,711,800.00	6,405,800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,878,800.00	3,581,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	833,000.00	2,824,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,084,291.00	1,936,860.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,463,200.00	635,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,313,200.00	00.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	150,000.00	635,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,621,091.00	1,301,860.45
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,621,091.00	1,301,860.45
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,888,400.00	13,149.50	893,529.64	2,795,079.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,888,400.00	13,149.50	893,529.64	2,795,079.14
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	5,682,553.04	5,682,553.04
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,888,400.00	00.00	10,269,110.35	12,157,510.35
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,888,400.00	00.00	10,269,110.35	12,157,510.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,888,400.00	00.00	10,269,110.35	12,157,510.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,932,937.44	-4,932,937.44
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,888,400.00	00.00	5,336,172.91	7,224,572.91

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	93,478,900.00	92,177,039.55	1,301,860.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	93,478,900.00	92,177,039.55	1,301,860.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,812,300.00	91,542,039.55	1,270,260.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48,999,700.00	48,826,894.25	172,805.75
210101	Үндсэн цалин	38,957,300.00	35,660,651.85	3,296,648.15
210102	Нэмэгдэл	00.00	4,589,782.40	-4,589,782.40
210104	Урамшуулал	10,042,400.00	8,576,460.00	1,465,940.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,319,100.00	6,067,971.30	251,128.70
210201	Тэтгэврийн даатгал	4,297,100.00	4,126,082.66	171,017.34
210202	Тэтгэмжийн даатгал	505,500.00	485,596.72	19,903.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	404,400.00	388,277.16	16,122.84
210204	Ажилгүйдлийн даатгал	101,100.00	97,318.57	3,781.43
210205	Эрүүл мэндийн даатгал	1,011,000.00	970,696.19	40,303.81
2104	Хангамж, бараа материалын зардал	6,951,500.00	6,825,400.00	126,100.00
210401	Бичиг хэрэг	750,000.00	1,230,900.00	-480,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,184,000.00	5,169,500.00	14,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	517,500.00	425,000.00	92,500.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	00.00	500,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	00.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	360,200.00	200,000.00	160,200.00
210702	Дотоод албан томилолт	360,200.00	200,000.00	160,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,450,600.00	13,215,974.00	234,626.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,933,400.00	12,904,000.00	29,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	144,000.00	90,000.00	54,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	80,000.00	00.00	80,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	51,974.00	28,026.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	00.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	173,200.00	170,000.00	3,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6731200.00	6405800.00	325,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,907,000.00	3,581,600.00	325,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,824,200.00	2,824,200.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	666600.00	635000.00	31,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	666,600.00	635,000.00	31,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	666,600.00	635,000.00	31,600.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	93,478,900.00	92,177,039.55	1,301,860.45
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	93,478,900.00	92,177,039.55	1,301,860.45
132001	Орон нутгийн төсвөөс	93,478,900.00	92,177,039.55	1,301,860.45

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдах байгууллагын хууль ёсоо дээдлэн, ил тод байдлыг хангасан, сумын хөгжлийн бодлогыг иргэдийн эрх ашигт нийцүүлэн оновчтой тодорхойлон хэрэгжилтийг хангуулж, иргэдийн эрх чөлөөтэй, ая тухтай ажиллаж амьдрах нөхцөл боломжоор хангах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01-р сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4.9 сая төгрөгөөр буюу 40.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

		/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б		1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.0	0.0	0.0
Авлага		0.0	0.0	0.0
Урьдчилгаа		0.0	0.0	0.0
Бараа материал		2,540.0	1,040.0	-1,500.0
Үндсэн хөрөнгө		9,617.5	6,184.6	-3,432.9
Нийт хөрөнгө		12,157.5	7,224.6	-4,932.9
Өр төлбөр		0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/		1,888.4	1,888.4	0.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн		12,157.5	7,224.6	-4,932.9

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын тушаалаар 1.5 сая төгрөгийн аж ахуйн материал акталснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 351.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,941.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталсан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 92,913.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 565.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 93,478.9 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 93,478.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 93,478.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 92,177.0 сая төгрөг буюу 98.6 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн удирдлага	93,478.9	92,177.0	1,301.9	98.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Б.Ариунболдод танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг Малчин сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хувьд суурь үзүүлэлтийг 2022 оны санхүүгийн тайлан гарах цаглаварт хугацаа болоогүй байгаа тул 2021 оны нийт зардлын дүнгээр сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 98,411.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 984.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн 80 хувиар буюу 787.3 мянган төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг арвилан хэмнэж, хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /С.БАТСАЙХАН/

2023 оны 02 сарын 10-ны өдөр